

## САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙСЭН ДҮНГИЙН ТУХАЙ

### НЭГ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО

Булган аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албаны 2019 оны хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөө аймгийн Засаг даргын баталсан 2019 оны 01 сарын 10-ны өдрийн 1/19 дугаар удирдамжийн дагуу Булган аймгийн Сайхан сумын сургуулийн 2018 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд Монгол Улсын Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулиуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актуудын хэрэгжилтийг шалгаж, зөрчил дутагдал илэрсэн тохиолдолд холбогдох хуулийн дагуу шийдвэрлэх, аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх, цаашид давтан гаргахгүй байх талаар мэргэжил арга зүйн заавар, зөвлөгөө өгөхөд чиглэгдлээ.

### ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БҮРЭЛДЭХҮҮН, ХУГАЦАА

Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч Б.Баттулга, Аудитор Б.Нямсүрэн нар 2019 оны 09 сарын 11-ны өдрөөс ажлын 6 өдөр шалгалтыг хийв.

### ГУРАВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД

Цэцэрлэгийн 2018 оны касс, харилцах дансны гүйлгээг санхүүгийн анхан шатны баримттай тулган шалгасны зэрэгцээ цалин хөлс, урамшуулал, албан томилолтын бодолт, олголт, шатахууны олголт түүний зарцуулалтыг автомашины замын хуудастай тулгаж, бараа материалын худалдан авалт, зарцуулалт, эд хөрөнгийн тооллого тооцоо бодолт, санхүү, төсвийн ил тод байдлын хэрэгжилт, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт зэрэг хяналт шалгалтын удирдамжид заагдсан асуудлуудыг бүрэн хамруулан захирал О.Болормаа, нягтлан бодогч Д.Цэнд-Аюуш нярав Д.Гантуяа нарыг байлцуулан төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийв.

### ДӨРӨВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН ОБЪЕКТЫН ТАЛААРХ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Булган аймгийн Сайхан сумын 12 жилийн сургууль нь Захирал 1, сургалтын менежер 2, нийгмийн ажилтан 1, багш 28, нягтлан бодогч 1, нярав 1, Тогооч 4, байрны багш 2, жижүүр 12, сахиул 1, үйлчлэгч 3, номын санч 1, жижүүр цахилгаанчин 1 нийт 58 орон тоотой үйл ажиллагаа явуулж байна. Тус сургуулийн 1-р гарын үсгийг 2018 онд

О.Болормаа, 2-р гарын үсгийг Д.Цэнд-Аюуш нар зурж орлого, зарлагын гүйлгээг хийж, хөрөнгө мөнгийг захиран зарцуулж иржээ.

## ЗУРГАА. ШАЛГАЛТЫН ЯВЦАД ХИЙГДСЭН АЖИЛ, ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД

6.1. Санхүүгийн эх үүсвэрийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаар: 2018 онд улсын төсвөөс 813158.7 мянган төгрөг. Ажиллагсдын цалин хөлсөнд 422568.8 мянган төгрөг олгосон. Нийгмийн даатгалын шимтгэлд 50656.5 мянган төгрөг, хангамжийн бараа материалын зардалд 5122.0 мянган төгрөг, байр ашигласантай холбоотой тогтмол зардалд 157595.9 мянган төгрөг, норматив зардалд 72457.8 мянган төгрөг, эд хогшил урсгал засварт 9697.2 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 813.3 мянган төгрөг, бараа үйлчилгээний зардалд 2917.9 мянган төгрөг, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 19472.0 мянган төгрөг, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилсаны тэтгэмж 21636.6 мянган төгрөг, үдийн цай хөтөлбөрт 21431.4 мянган төгрөг зарцуулж 25248.2 мянган төгрөг төсөвт төвлөрүүлсэн байна.

Цалин урамшууллын талаар: Хангал сумын цэцэрлэгийн эрхлэгчийн 2018 оны 03 сарын 12-ний өдрийн Б/04 тоот тушаалаар туслах багш Л.Мандхад хөдөө орон нутагт тогтвор сууршилтай ажилсаны тэтгэмж 2682.0 мянган төгрөг бодож олгосон. Мөн оны 03 сарын 19-ний өдрийн Б/6 тоот тушаалаар багш, ажилчдын 1-р улиралын үр дүнгийн урамшуулалд 1175.2 мянган төгрөг, 2018 оны 04 сарын 03-ний өдрийн Хангал сумын Засаг даргын Б/11 тоот захирамжаар эрхлэгч Б.Буяннэмхийн үр дүнгийн гэрээг дүгнэж үндсэн цалингийн 40%-иар буюу 231.1 мянган төгрөг, 2018 оны 06 сарын 14-ний өдрийн А/09 тоот тушаалаар 2-р улиралын үр дүнгийн урамшуулалд 1085.8 мянган төгрөг, 09 сарын 25-ний өдрийн Б/18 тоот тушаалаар туслах багш Л.Өнөрцэцэг, тогооч Н.Цагаанчулуун нарт ур чадварын нэмэгдэл 15%-иар буюу 134.2 мянган төгрөг, 09 сарын 25-ний өдрийн Б/19 тоот тушаалаар нярав Л.Мандхад ур чадварын нэмэгдэл 25%-иар буюу 126.6 мянган төгрөг, 2018 оны 10 сарын 03-ний Б/20 тоот тушаалаар 3-р улиралын үр дүнгийн урамшуулалд 880.3 мянган төгрөг, аймгийн Засаг даргын 2018 оны 09 сарын 26-ний өдрийн А/583 тоот захирамжаар эрхлэгчийн 2-р улиралын үр дүнгийн урамшуулалд 159.5 мянган төгрөг, аймгийн засаг даргын 2018 оны 12 сарын 06-ний өдрийн А/696 тоот захирамжаар 3-р улиралын үр дүнгийн урамшуулалд 107.8 мянган төгрөг, аймгийн Засаг даргын 12 сарын 20-ний өдрийн А/912 тоот захирамжаар 4-р улиралын үр дүнгийн урамшуулалд 218.3 төгрөг, 2018 оны 12 сарын 10-ний өдрийн А/32 тоот тушаалаар багш Ц.Нарантуяад 19468.8 мянган төгрөгийн тэтгэмж, Хангал сумын Засаг даргын 2018 оны 11 сарын 27-ний өдрийн А/165 тоот захирамжаар эрхлэгч Ж.Цэрмаад 100.0 мянган төгрөгийн урамшуулалыг тус тус бодож олгосон байна.

### 6.2. Үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлт: 2018 он

№	Нэр	Мөнгөн дүн /төгрөгөөр/			
		Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл

1	Барилга байгууламж	3016918.9	1151967.8	1814434.5	2354452.1
2	Тээврийн хэрэгсэл	9500			9500
3	Тоног төхөөрөмж	169233.1	1964.9	0	171197.9
4	Тавилга	97639.8	7157.7		104797.5
5	Ном	18734.7	2016.0	0	20750.7
6	Программ	466.0			466.0
7	Биет бус хөрөнгө газар		27402.4		27402.4
	<b>Дүн</b>	<b>3312492.5</b>	<b>1190508.8</b>	<b>1814434.6</b>	<b>2688566.8</b>

2018 оны эхэнд 3312492.5 мянган төгрөгийн үндсэн бүртгэгдсэн байна. Үүнээс 3016918.9 мянган төгрөг буюу 91 хувь нь барилга байгууламж, 9500 мянган төгрөг буюу 0.2 хувь нь тээврийн хэрэгсэл, 169233.1 мянган төгрөг буюу 5 хувь нь тоног төхөөрөмж, 97639.8 мянган төгрөг буюу 2.9 хувь нь тавилга, 18734.7 мянган төгрөг буюу 0.5 хувь нь ном, 466 мянган төгрөгийн программ хангамж байна. Үндсэн хөрөнгө дээр төсвийн хөрөнгөөр 2953.3 мянган төгрөгийн хөрөнгө авснаас барилга байгууламж дахин үнэлгээнд орж 1269370.2 мянган төгрөгөөр нэмэгдэж, боловсрол соёл шинжилэх ухааны яамнаас үнэ төлбөргүй авсан 5936.7 мянган төгрөгний тавилга, 1683.6 мянган төгрөгийн ном сурах бичиг хандиваар авсан байна. Оны эцэст 2688566.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгүүлсэн байна.

### 6.3. Бараа материалын хөдлөл өөрчлөлт:2018 он

№	Тайлангийн нэр	Мөнгөн дүн /төгрөгөөр/			
		Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
1	Эм боох материал	185.9	487.8	500.8	172.9
2	Бичиг хэрэг	578.5	9360.4	8648.2	1290.8
3	Аж ахуйн материал	35670.0	4568.5	3514.8	36723.8
4	Түлш шатахуун		4282.6	4282.6	
5	Хүнс	24341.6	69839.7	70811.2	23370.1
	<b>НИЙТ ДҮН</b>	<b>60776.0</b>	<b>88539.1</b>	<b>87757.6</b>	<b>61557.5</b>

2018 оны эхэнд 60776.0 мянган төгрөгний бараа материал дээр төсвийн хөрөнгөөр 88121.6 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүй авсан, 417.5 мянган төгрөгийн бараа материал хандиваар авсан, 84242.8 мянган төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаанд зарцуулж, цаашид ашиглах боломжгүй болсон 3514.8 мянган төгрөгийн аж ахуйн материалыг данснаас хасч оны эцэст 61557.5 мянган төгрөгийн бараа материал бүртгэгдсэн байна.

### 6.4. Өглөг, авлагын талаар: 2018 онд өр, авлагын тооцоо байхгүй байна

6.5 Шилэн дансны талаар: Шилэн дансны тухай хуулийн дагуу шилэн дансны нэгдсэн системд 2018 төсөв гүйцэтгэлийн 49 мэдээлэл оруулхаас 1 мэдээлэл хоцроож, 48 мэдээлэлийг хугацаанд нь оруулсан. Хөрөнгө оруулалт, тендер худалтан авалтын

39 мэдээлэл оруулхаас 38 мэдээлэлийг хугацаанд нь оруулж 1 мэдээг хугацаа хоцроож оруулсан, бусад төрлийн 61 мэдээ оруулахаас 60 мэдээг хугацаанд нь оруулж 1 мэдээлэл хугацаа хоцроож оруулсан байна.

**ДОЛОО. ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ТҮҮНИЙ ШАЛТГААН,  
ЗӨРЧИГДСӨН ХУУЛЬ, ТОГТООМЖ**

1. 2018 оны 10 дугаар сарын 24-ны өдрийн 00248 төлбөрийн хүсэлтээр У.Нарангэрэлийн 5279115984 дугаартай дансанд бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний зардлаас 100.0 мянган төгрөгийн Бооцооны үнэ-д шилжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 16.5 /Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: ... 16.5.5 батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/-д заасныг зөрчсөн байна.

2. 2018 оны 3 дугаар сарын 15 –ны өдрийн 36 тоот төлбөрийн хүсэлтээр О.Болормаа, 15000 нэгж, Л.Лхагвадорж, Х.Баяраа, Д.Гантуяа, Д.Отгончимэг, Н.Сугар нарт тус бүр 10000 нэгж А.Бадамсүрэн, С.Лхагважав, З.Золжаргал, Ч.Цогзол нарт 5000 нэгж нийт 90000 төгрөгийн нэгжийг шилжүүлсэн нь

3. Номыг бүртгэлд орлогодож авдаггүй.

**НАЙМ. АВСАН АРГА ХЭМЖЭЭ, МЭРГЭЖЛИЙН ТУСЛАЛЦАА,  
ЗӨВЛӨГӨӨ ӨГСӨН БАЙДАЛ**

Шалгалтын хугацаанд 3 албан тушаалтанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв.

**ЕС. ДҮГНЭЛТ**

Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.5, 13.7 дахь /шинэчилсэн/ заалтууд, няравын тайлан гаргалт анхан шатны баримтын бүрдэлт маш сайн.

Ололт дэвшилттэй тал нь эд хөрөнгийн тоололгын бүртгэл, харилцахын баримт, хөтлөлт, материалын эмх цэгц сайн байна.

**АРВАН НЭГЭН. ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ**

Санхүүгийн үйл ажиллагаандаа дотоодын хяналт шалгалтыг тогтмол хийж албан тодорхойлолт гаргах

Төсвийн тухай хууль,

**БИЧСЭН: АУДИТОР**

**Б.НЯМСҮРЭН**